

ШИЛДЭГ БҮТЭЭЛИЙН УРАЛДААН

НЭГ. ЕРӨНХИЙ

Монгол Улсад санхүүгийн зохицуулагч байгууллага байгуулагдсаны 25 жил, даатгалын салбарын 85 жилийн ойд зориулан судлаачид, оюутнуудын дунд шилдэг бүтээлийн уралдааныг зарлаж байна.

ХОЁР. ЗОРИЛГО

Санхүү, бизнес, эдийн засгийн чиглэлийн судлаачид болон оюутнуудын бүтээл туурвих чадварыг дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлж, санхүүгийн байгууллагын талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд оршино.

ГУРАВ. СЭДВИЙН ЧИГЛЭЛ

Шилдэг бүтээлийн уралдаанд оролцохоор сонирхож буй судлаач, оюутан нийт 3 сэдвийн хүрээнд судалгааны бүтээлийг туурвина.

БҮТЭЭЛИЙН СЭДЭВ: Даатгал, Хөрөнгийн зах зээл, Бичил санхүүгийн зах зээлийг хамарна.

Бүтээлийн чиглэл:

1. Санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх боломж, арга зам;
2. Санхүүгийн зах зээлийн эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх боломж, тулгамдаж буй асуудал;
3. Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх байгууллагуудын эрсдэл даах чадвар, эрсдэлийг урьдчилан тооцох аргачлал.

ДӨРӨВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Нэгдүгээр шат: Судалгааны бүтээлийг ирүүлэх:

- ✓ Сэдвийн хүрээнд өөрийн судалгааны бүтээл бичих:
 - Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, судалгааны бүтээлийн нэрийг бичих;
 - Судалгааны ажлаа бичгийн А4 цаасан дээр бичих бөгөөд дээд тал нь 15 хуудсанд багтсан байх;
 - Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
 - Бусдын оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах)
- ✓ Бичгийн стандарт:
 - Үсгийн фонд – Times New Roman;
 - Үсгийн хэмжээ- 12;
 - Мөр хоорондын зай – 1,5;
 - Margins: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм.
- ✓ Бүтээл нь судалгааны нэр, агуулга, хураангуй, оршил, судлагдсан байдал, судалгааны аргачлал, шинжилгээний хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх;
- ✓ Судалгааны бүтээлийг дараах шалгуур үзүүлэлтүүдээр шалгаруулна:
 - Онол, аргазүйн үндэслэлтэй;
 - Шинэлэг, оновчтой санал, санаачилгыг дэвшүүлсэн;
 - Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан;
 - Эконометрик, статистикийн арга хэрэгслүүдийг ашигласан;
 - Оюутны ангилалд оролцох судалгааны ажлууд заавал удирдагч багштай байх;
 - Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, үр дүнд хүрсэн байх;
 - Бусад судлаачдын ажлыг шууд хуулбарлаагүй байх;
 - Өөрийн судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдсан байх.

Хоёрдугаар шат: Судалгааны ажлыг хэлэлцүүлэх илтгэл

- Илтгэлийг PowerPoint хэлбэрээр ирүүлэх:
 - Илтгэл нь гарчиг, агуулга, оршил, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх;
- Илтгэх чадвар:
 - Үзэгчдэд санаагаа хүргэх чадвар (ойлгомжтой, цэгцтэй);
 - Хувцаслалт, биеийн хэл;
 - Үгийн сонголт, ярианы чадвар ;
 - Илтгэлийн хугацаа: 15 минут.
- Илтгэлийн шалгуур үзүүлэлт:
 - Илтгэл сэдвийн хүрээнд байгаа эсэх
 - Илтгэлийн бүтэц зохион байгуулалт
 - Илтгэлийн шинэлэг санаа гаргасан байдал

Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулж буй бүтээлийн уралдаан нь дээрх шаардлагыг хангасан материал илгээж буй оролцогч бүрт нээлттэй бөгөөд мэргэжил, нас, хүйс, иргэншил харгалзахгүй болно.

ТАВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- 1 дүгээр шат: Зохион байгуулах комисс судалгааны ажлыг 2019 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 18.00 цаг хүртэл бүтээлийг хэвлэмэл (2 хувь) болон цахим хэлбэрээр Санхүүгийн зохицуулах хорооны 405 тоот өрөө болон rsa@frc.mn хаягаар хүлээн авна. Судалгааны бүтээлтэй танилцан, үнэлэлт өгч судлаачийн ангилалд 6 бүтээл, оюутны ангилалд 6 бүтээлийг хоёрдугаар шатанд сонгон шалгаруулна.
- 2 дугаар шат: Эхний шатнаас шалгарсан судалгааны ажлуудыг 2019 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр буюу Мягмар гарагт мэдэгдэх бөгөөд, шалгарсан оролцогчид хоёр дугаар шатанд танилцуулах илтгэлийг 11 дүгээр сарын 14-ний өдрийн 17 цагаас өмнө rsa@frc.mn хаягаар ирүүлэх. Эхний шатанд шалгарсан илтгэлээр 11 дүгээр сарын 15-ны өдөр эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулна.
- Шагналт байранд шалгарсан оролцогчдын шагналыг Санхүүгийн зохицуулагч байгууллага байгуулагдсаны 25 жилийн ойн баярын арга хэмжээний үеэр гардуулна.
- Шалгарсан бүтээлүүдийг Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны вебсайт, социал сувгуудаар олон нийтэд түгээх бөгөөд 2 дугаар шатанд шалгарсан оролцогчдын бүтээлийг эмхэтгэл болгон хэвлүүлэх эсхүл СЗХ-ноос эрхлэн гаргадаг “Хүртээмжтэй санхүү” сэтгүүлд хэвлүүлэх болно.

ЗУРГАА. ШАГНАЛЫН САН

6.1. Судлаачдын ангилал

- 1-р байр - Өргөмжлөл, 2 000 000 /Хоёр сая төгрөг/;
- 2-р байр - Өргөмжлөл, 1 500 000 /Нэг сая таван зуун мянган төгрөг/;
- 3-р байр - Өргөмжлөл, 1 000 000 /Нэг сая төгрөг/.

6.2. Оюутны ангилал

- 1-р байр - Өргөмжлөл, 1 000 000 / Нэг сая төгрөг/;
- 2-р байр - Өргөмжлөл, 700 000 /Долоон зуун мянган төгрөг/;
- 3-р байр - Өргөмжлөл, 500 000 /Таван зуун мянган төгрөг/.

ДОЛОО. ХОЛБОО БАРИХ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улс, Улаанбаатар хот 15160, Чингэлтэй Дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр. Дэлгэрэнгүй мэдээллийг www.frc.mn вэб хуудаснаас болон (976) 51-261012 болон 94022322, 88109190 утсаар лавлана уу.